

Дуу Бичлэг Бүтээгчдийн Үндэсний төвийн  
Удирдах зөвлөлийн 2026.05.11-ны  
өдрийн тогтоолоор батлав

# МСРР

MONGOLIAN CENTRE OF PHONOGRAMM AND PRODUCERS

## ДУУ БИЧЛЭГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ, ХУВААРИЛАХ ЖУРАМ

МСРР-ийн дүрэм болон

IFPI · RIAK · FKMP · SoundExchange · WPPT · Ромын конвенцийн стандартыг үндэслэсэн

УЗ-ийн тогтоолоор батална • Хувилбар 1.0 • 2026 оны 5-р сар • Улаанбаатар хот

## ХЭРЭГЛЭСЭН ОЛОН УЛСЫН ДҮРЭМ ЖУРАМ, ЭРХ ЗҮЙ

Энэхүү журмыг дараах олон улсын гэрээ, дүрэм журам болон тухайн байгууллагуудын хуваарилалтын стандартыг үндэс болгон боловсруулав.

| Эрхзүйн баримт бичиг                            | Огноо     | Хамааралтай заалт                                                                                                                                                                                       | МСПР-д хэрэглэгдэх хэсэг                                 |
|-------------------------------------------------|-----------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|
| Ромын конвенц (Rome Convention)                 | 1961      | Гүйцэтгэгч, фонограмм бүтээгч, нэвтрүүлэгчийн эрхийн олон улсын стандарт                                                                                                                                | Хамаарах эрхийн үндсэн суурь                             |
| TRIPS Хэлэлцээр (WTO, 1994)                     | 1994      | Оюуны өмчийн нийтлэг стандарт, хамаарах эрхийг хамарна                                                                                                                                                  | Шаардлагатай хамгаалалтын доод хэмжээ                    |
| WIPO Performances and phonograms Treaty (WPPT)  | 1996      | Гүйцэтгэгч ба фонограмм бүтээгчийн эрхийн хамгаалалт                                                                                                                                                    | Мэдэгдлийн эрх, эдийн засгийн эрх                        |
| IFPI стандарт (олон улсын)                      | 2024      | Гүйцэтгэлийн эрхийн орлого: дэлхийд \$2.9 тэрбум (2024), ХУБ-уудын стандарт                                                                                                                             | Дуу бичлэг ашигласны төлбөр цуглуулах, хуваарилах загвар |
| RIAK дүрэм (Солонгос)                           | 2000–2024 | Фонограмм бүтээгчийн хамаарах эрх; Солонгосын Зохиогчийн эрхийн хуулийн 76-2, 83-2-р зүйл                                                                                                               | Мастер эрхийн хуваарилалтын загвар                       |
| SoundExchange дүрэм (АНУ, 17 U.S.C. §112, §114) | 2000–2024 | Голлох гүйцэтгэгч 45%, эрх эзэмшигч (мастер) 50%, нэмэлт гүйцэтгэгч 5% — Хуулиар тогтоосон                                                                                                              | Гүйцэтгэгч ба мастер эзэмшигчийн хуваарилалт             |
| МУ-ын Зохиогчийн эрхийн тухай хууль             | 2021      | ХУБ-ын журам 2.2.3: төлбөрийг гэрээгээр тохиролцсон хувиар олгох                                                                                                                                        | ЗЭ, Хамаарах эрх, эрхзүйн суурь                          |
| МУ-ын ХУБ-ын журам (А/17 тушаал, 2021)          | 2021      | 3.3.5: Дуу бичлэг ашигласны төлбөр хураах, хуваарилах журам                                                                                                                                             | ОӨГ-ын гэрээний шаардлага                                |
| МСПР-ийн дүрэм                                  | 2026      | 3.3: "Дуу бичлэг ашигласны төлбөр цуглуулах, хуваарилах журам"-ыг УЗ-ийн тогтоолоор батална 5.1–5.4: 25% суутгал, тариф тогтоох, ОӨГ-ын ЗЭ зөвлөлийн батламж 6.2: нөөцийн сан 7.1–7.4: тайлагнал, аудит | Энэхүү журмын үндсэн эрхзүйн суурь                       |

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Журмын зорилго

Энэхүү "Дуу бичлэг ашигласны төлбөр цуглуулах, хуваарилах журам" нь МСПР-ийн дүрмийн 3.3-т заасны дагуу Удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдаж, дүрмийн 5.1–5.4 болон 3.2.4-д тодорхойлсон хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх зорилготой.

- ▶ МСПР дүрэм 3.3: "Зорилго зорилтоо биелүүлэх үйл ажиллагааны хүрээнд "Дуу бичлэг ашигласны төлбөр цуглуулах, хуваарилах журам"-ыг Удирдах зөвлөлөөс тогтоол гаргаж батална."
- ▶ МСПР дүрэм 3.2.4: "Дуу бичлэг ашигласны төлбөрийг эрх эзэмшигч, бичлэгийн эрх эзэмшигч эрх бүхий гишүүддээ шударгаар хуваарилах"
- ▶ МСПР дүрэм 3.2.3: "Гишүүдээ төлөөлөн дуу бичлэг хэрэглэгч хувь хүн, байгууллагад зөвшөөрөл олгож төлбөрийг цуглуулах"
- ▶ IFPI (2024): "Music licensing companies, authorised by record labels, collect revenue from businesses and distribute it to the relevant artists and producers" — МСПР нь Монголд энэ үүргийг гүйцэтгэнэ.
- ▶ WPPT (1996) Art. 15: Гүйцэтгэгч ба фонограмм бүтээгч нь радио нэвтрүүлэг болон нийтийн газарт ашиглалтаас "шударга нөхөн төлбөр" авах эрхтэй.
- ▶ МУ-ын ХУБ-ын журам (2021) 2.2.3: "эрх эзэмшигчид энэ журмын 2.2.2-т заасан төлбөрөөс гэрээгээр тохиролцсон хувийг олгох"

### 1.2 Хамрах хүрээ

Энэ журам нь МСПР-ийн дүрмийн дагуу гэрээ байгуулсан гишүүд болон МСПР-тэй харилцан төлөөлөх гэрээ байгуулсан гадаадын байгууллагуудын гишүүдийн дараах орлогод хамаарна:

- Нэвтрүүлэгч (ТВ, радио, IPTV, OTT, Satellite)-ийн лицензийн орлого
- Дижитал платформ (стриминг, CRBT, мобайл)-ийн орлого
- Нийтийн газар (ресторан, клуб, дэлгүүр, зочид буудал)-ийн лицензийн орлого
- Амьд тоглолтын тасалбарын орлогоос авах хамаарах эрхийн төлбөр
- Гадаадын ХУБ-уудаас WIPO-Connect/SCAPR-аар хүлээн авах олон улсын хуваарилалт

### 1.3 Хуваарилалтын үндсэн зарчим

МСПР-ийн дүрмийн 5.4-т заасны дагуу "Дуу бичлэгийн ашиглалтын мэдээлэлд үндэслэн гишүүн бүрт ил тод, олон улсад батлагдсан аргачлалаар хуваарилна." IFPI, FKMP, RIAK, SoundExchange болон WPPT, Ромын конвенцийн стандартад нийцүүлэн дараах зарчмыг баримтална:

| Зарчим                              | МСПР дүрмийн заалт | Олон улсын үндэслэл                   | Агуулга                                                           |
|-------------------------------------|--------------------|---------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1. Ашиглалтад суурилсан хуваарилалт | Дүрэм 5.4          | IFPI CMO Toolkit; FKMP дүрэм          | Дуу бичлэг ашиглагдсан тоогоор авна (chart) — тогтмол дүнгээр бус |
| 2. Ил тод байдал                    | Дүрэм 4.11.8, 7.2  | WPPT Art. 20; МУ-ын ХУБ-ын журам 4.1  | Гишүүн тус бүр өөрийн орлогын задаргааг харах эрхтэй              |
| 3. Шударга байдал                   | Дүрэм 3.2.4        | WPPT Art. 15 "equitable remuneration" | Гүйцэтгэгч ба мастер эзэмшигч хоёулаа хуваарилалт авна            |
| 4. Хуваарилалт                      | Дүрэм 5.3, 5.4     | RIAK, FKMP: улирал тутам              | Улирал тутам цуглуулсан төлбөрийг орлого цуглуулж                 |

|                                |                |                             |                                                     |
|--------------------------------|----------------|-----------------------------|-----------------------------------------------------|
|                                |                |                             | захиргааны зардал<br>суутгасны дараа                |
| 5. УЗ-ийн тогтоолоор<br>батлах | Дүрэм 3.3, 9.1 | МУ-ын ХУБ-ын журам<br>3.3.4 | Тарифыг ОӨГ-ын ЗЭ<br>зөвлөлийн<br>баталгаажуулснаар |
| 6. Аудитын хяналт              | Дүрэм 7.3, 7.4 | МУ-ын ХУБ-ын журам<br>4.4   | 2 жилд нэг удаа<br>хөндлөнгийн аудит                |

# ХОЁР. ОРЛОГО ЦУГЛУУЛАЛТ БА ЗАХИРГААНЫ СУУТГАЛ

## 2.1 Орлогын ангилал ба ашиглалтын тооцооллын үндэс

МСПР нь орлогыг дараах 5 ангиллаар ялгаж, тус бүрийн ашиглалтын байдлыг тодорхой аргачлалаар тооцоолно:

| Ангилал              | Ашиглалт тооцооллын үндэс                                                          | Мэдээлэл цуглуулах арга                                                   | Олон улсын загвар                         |
|----------------------|------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|-------------------------------------------|
| Амьд тоглолт         | Тасалбарын нийт орлого × 1% ÷ нийт дуу, бичлэг × МСПР дуу, бичлэг × тоглогдсон тоо | Лицензийн өргөдлийн тасалбарын мэдээлэл, уг журмын 4.4 зүйлийг баримтална | FKMP: тасалбарын орлогын хувь             |
| Радио/ТВ нэвтрүүлэг  | Cue sheet (ямар дуу, хэдэн минут) × нэгжийн тариф → ISRC кодоор тохируулна         | Нэвтрүүлэгчийн сарын cue sheet (гэрээгээр үүрэгжсэн)                      | FKMP BROMIS систем: 36 нэвтрүүлэгчтэй API |
| Дижитал стриминг     | Нийт орлого × 65% (МСПР тариф) ÷ нийт ашиглалтаас МСПР дуу, бичлэгийн хувь         | Платформын сарын тайлан (ISRC кодоор)                                     | RIAK ~48% (мастер), SoundExchange 45%+50% |
| Нийтийн газар        | Тогтмол тариф (гэрээгээр) → ашиглалтын хувьд тэнцвэрлэн хуваарилна                 | Гэрээний жагсаалт × тариф                                                 | FKMP/RIAK: тогтмол тариф, м² үндэслэл     |
| Гадаадын хуваарилалт | Гадаадын ХУБ-аас DDEX/CWR форматаар ирэх тайлан → ISRC кодоор тохируулна           | WIPO-Connect дамжуулан автомат                                            | SCAPR, SoundExchange харилцан гэрээ       |

## 2.2 Захиргааны суутгал

МСПР-ийн дүрмийн 5.3-т заасны дагуу: "Цуглуулсан нийт төлбөрөөс үйл ажиллагаа болон захиргааны зардалд 20 хувийг, нөөцийн санд 5 хувийг нийт 25 хувийг хасаж суутгасны дараа хуваарилалтыг хийнэ." Олон улсын ХУБ-уудын стандартад нийцүүлэн дараах суутгалын бүтцийг баримтална:

- ▶ МСПР дүрэм 5.3: "Цуглуулсан нийт төлбөрөөс үйл ажиллагаа болон захиргааны зардалд 20 хувийг, нөөцийн санд 5 хувийг, нийт 25 хувийг хасаж суутгасны дараа хуваарилалтыг хийнэ."
- ▶ МСПР дүрэм 6.2: "Удирдах зөвлөлийн шийдвэрээр нийт орлогоос захиргааны зардалын 25%-ын хувиас нөөцийн санд 5 хувийг авч үлдэнэ."
- ▶ МСПР дүрэм 5.4: "Цуглуулсан төлбөрийг: дуу бичлэгийн ашиглалтын мэдээлэлд үндэслэн гишүүн бүрт ил тод, олон улсад батлагдсан аргачлал, журмын дагуу хуваарилна"
- ▶ МУ-ын ЗЭ-ийн хуулийн (2021) 49.4: "Үйл ажиллагааны зардал нь дуу бичлэг ашиглалтын төлбөрийн орлогын 25 хүртэл хувийг суутган авна"
- ▶ IFPI CMO Toolkit: "Administrative deductions must be transparent and reasonable" — ил тод, үндэслэлтэй байх шаардлагатай

| Суутгалын зүйл             | Хувь | МСПР дүрмийн заалт                         | Олон улсын үндэслэл              |
|----------------------------|------|--------------------------------------------|----------------------------------|
| Захиргааны зардлын суутгал | 20%  | Дүрэм 5.3: "нийт 25 хувийг хасаж суутгана" | МУ-ын ЗЭ-ийн хуулийн (2021) 49.4 |

|                            |           |                                               |                                 |
|----------------------------|-----------|-----------------------------------------------|---------------------------------|
| Нөөцийн сан                | 5% хүртэл | Дүрэм 6.2: "нөөцийн санд 5 хувийг авч үлдэнэ" | МУ-ын ХУБ-ын журам; IFPI загвар |
| Гишүүдэд хуваарилах роялти | 75%       | Дүрэм 5.3, 5.4: "хуваарилалтыг хийнэ"         | WPPT Art. 15; Ромын конвенц     |

Тайлбар: 75%-ийн дотроос гүйцэтгэгч ба мастер эзэмшигчийн хуваарилалт тус бүрийн гэрээний дагуу нарийвчлагдана (доорх 3-р бүлэгт). Нөөцийн сангийн зарцуулалтыг журмын дагуу зохицуулна.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ БА МАСТЕР ЭЗЭМШИГЧИЙН ХУВААРИЛАЛТ

### 3.1 Үндсэн хуваарилалтын харьцаа — олон улсын стандарт

Орлогыг захиргааны суутгал хийсний дараа голлох хүлээн авагчдад хуваарилах загвар нь дараах олон улсын стандартуудад суурилна:

| Байгуулага                  | Голлох гүйцэтгэгч            | Мастер / эрх эзэмшигч   | Нэмэлт гүйцэтгэгч                      | Хуулийн үндэслэл                                 |
|-----------------------------|------------------------------|-------------------------|----------------------------------------|--------------------------------------------------|
| SoundExchange (АНУ)         | 45%                          | 50%                     | 5% (сан)                               | 17 U.S.C. §114(g)(2) — хуулиар тогтоосон         |
| FKMP (Солонгос)             | Гүйцэтгэгч: 50–60%           | Бичлэгийн эзэн: 40–50%  | Хэлэлцэн тогтооно                      | Солонгосын Зохиогчийн эрхийн хуулийн 76-2-р зүйл |
| RIAK (Солонгос)             | Гүйцэтгэгч: 50%              | Мастер: 50%             | Нэмэлт: тохиролцоогоор                 | Солонгосын Зохиогчийн эрхийн хуулийн 83-2-р зүйл |
| Европын стандарт (PPL, GVL) | Гүйцэтгэгч: 50%              | Мастер: 50%             | Хэсэгчилсэн гүйцэтгэгч: тусдаа         | EU Neighboring Rights Directive                  |
| МСРР (Монгол) — санал       | Голлох гүйцэтгэгч: гэрээгээр | Мастер/лейбл: гэрээгээр | Хэсэгчилсэн гүйцэтгэгч: тохиролцоогоор | ХУБ журам 2.2.3, гэрээгээр                       |

- ▶ SoundExchange (17 U.S.C. §114): "50% to the sound recording copyright owner, 45% to the featured artist, 5% to non-featured artists" — хуулиар тогтоосон хуваарилалт. Гүйцэтгэгчийн 45%-ийг лейблийн гэрээнээс үл хамааран ШУУД гүйцэтгэгчид олгоно.
- ▶ RIAK: Фонограмм бүтээгчийн (음반제작자) хамаарах эрхийг хамтарсан мэдэгдлийн дагуу хуваарилна.
- ▶ WPPT (1996) Art. 15.1: Гүйцэтгэгч ба фонограмм бүтээгч нэвтрүүлэг/олон нийтийн газрын ашиглалтаас "шударга нөхөн төлбөр" хамтаар авах эрхтэй.

### 3.2 Голлох гүйцэтгэгчийн (featuring artist) хуваарилалт

МСРР-ийн дүрмийн 4.11.1-д гишүүн нь "Оюуны өмч, хамаарах эрхийн эзэмшигч, фонограмм, бичлэг үйлдвэрлэгч, дуу бичлэгийн эрх эзэмшигч болон өв залгамжлагч" байна. Голлох гүйцэтгэгч гэдэг нь дуу бичлэг дээр нэрлэгдсэн, гол дуу хоолойг бий болгосон уран бүтээлчийг хэлнэ.

- ▶ SoundExchange тодорхойлолт: "Featured artist — the principal performer(s) credited on the recording"
- ▶ FKMP тодорхойлолт: 주실연자 — голлох дуучин, хамтлагийн ахлах гишүүн
- ▶ МУ-ын ЗЭ хуулийн 4.1.23: "нийтэд тоглох" — дуулах, хөгжимдөх зэргээр гүйцэтгэж үзүүлэх

| Хуваарилалтын загвар | Хувь | Тайлбар | Эрхзүйн үндэслэл |
|----------------------|------|---------|------------------|
|----------------------|------|---------|------------------|

|                                                  |                  |                                                           |                                                      |
|--------------------------------------------------|------------------|-----------------------------------------------------------|------------------------------------------------------|
| Голлох гүйцэтгэгч — нийт хуваарилалтаас          | гэрээгээр        | Гүйцэтгэгчийн хамаарах эрхийн хувь                        | WPPT Art.15, SoundExchange 45%, FKMP загвар          |
| Хамтлагийн тохиролцоо                            | Дотоод гэрээгээр | Хамтлагийн доторх хуваарийг тус тусын гэрээгээр тогтооно  | SoundExchange Letter of Direction загвар             |
| Бие даасан дуучин (мастер эзэмшигч нь өөрөө бол) | 95–100%          | Гүйцэтгэгч + мастер хоёуланг нь эзэмшиж байгаа тохиолдолд | SoundExchange: 45%+50%=95% бие даасан уран бүтээлчид |

### 3.3 Мастер/Бичлэгийн эрх эзэмшигчийн (Sound Recording Owner) хуваарилалт

Мастер/Фонограмм бүтээгч гэдэг нь бичлэгийг санхүүжүүлж, үйлдвэрлэсэн хуулийн этгээд буюу хувь хүнийг хэлнэ — ихэвчлэн студи, лейбл, буюу бие даасан продюсер.

- Ромын конвенц (1961) Art. 3(c): PHONOGRAMM producer — "the person who, or the legal entity which, first fixes the sounds of a performance"
- WPPT (1996) Art. 11: Фонограмм бүтээгч нь бичлэгийнхээ шууд болон шууд бус хуулбарлалтыг зөвшөөрөх онцгой эрхтэй.
- RIAK: Солонгосын Зохиогчийн эрхийн хуулийн 83-2-р зүйлийн дагуу бичлэгийн эрх эзэмшигч нийтийн газрын ашиглалтаас нөхөн төлбөр авна.
- SoundExchange (17 U.S.C. §114): Sound Recording Copyright Owner — 50% тогтмол хуваарилалт.

| Мастер эзэмшигчийн төрөл            | Хувь               | Тайлбар                                       | Шаардлага                                         |
|-------------------------------------|--------------------|-----------------------------------------------|---------------------------------------------------|
| Студи / Бичлэгийн лейбл             | 50%                | Бичлэгийг санхүүжүүлсэн байгууллага           | МСПП-д бүртгэлтэй, ISRC код дор бүртгэгдсэн байна |
| Бие даасан продюсер                 | 50%                | Өөрийн санхүүгээр бичлэг хийсэн хувь хүн      | Мастер эзэмшлийн баримт ирүүлнэ                   |
| Хамтарсан мастер (продюсер + лейбл) | 50% хооронд хуваах | Мастер эзэмшлийн гэрээгээр хувийг тодорхойлно | Заагдсан хувийн гэрээний хуулбарыг МСПП-д ирүүлнэ |
| Гүйцэтгэгч өөрөө мастер эзэмшигч    | 50%+50%=100%       | Бие даасан — гүйцэтгэгч ба мастер нэг хүн     | Хоёр үүргийг тусад нь бүртгүүлнэ                  |

### 3.4 Нэмэлт/Хэсэгчилсэн гүйцэтгэгчийн (Non-Featured Artist) хуваарилалт

Нэмэлт гүйцэтгэгч гэдэг нь бичлэг дэх хамтлагийн гүйцэтгэгч, найрал хоолой, хэсэгчилсэн хөгжимчдийг хэлнэ.

- SoundExchange (17 U.S.C. §114(g)(2)(B)): Non-featured artists — 5% goes to a fund administered by AFM and SAG-AFTRA — сан руу хуримтлагдаж, мэргэжлийн холбоогоор хуваарилагдана.
- FKMP (한국음악실연자연협회): 부실연자 (нэмэлт гүйцэтгэгч) — голлох гүйцэтгэгчийн хувиас тусдаа нэмэлт хувь авна.
- WPPT (1996): Гүйцэтгэгч бүр адил хамгаалалт эдлэх эрхтэй, харин хуваалтыг иргэний хуулиар зохицуулна.

| Нэмэлт гүйцэтгэгчийн ангилал              | МСПР хуваарилалт               | Аргачлал                                         | Жишиглэл                                   |
|-------------------------------------------|--------------------------------|--------------------------------------------------|--------------------------------------------|
| Хэсэгчилсэн хөгжимчид (хамтлагийн гишүүд) | Гүйцэтгэгчийн тохиролцоогоор   | Дуу, бичлэгт тоглолцсон гишүүдийн гэрээний дагуу | SoundExchange: AFM сан                     |
| Арын дуучид, найрал дуучид                | Гүйцэтгэгчийн тохиролцоогоор   | Хувийн гэрээ + МСПР-д бүртгэгдсэн байна          | FKMP: 부실연자 хуваарилалт                     |
| Зохиолч нь мөн гүйцэтгэгч тохиолдолд      | Гүйцэтгэгчийн хувиас нэмэлтээр | Хоёр үүргийг тусад нь бүртгүүлнэ (МСПР + MOSCAP) | FKMP гишүүн нь КОМСА-д ч гишүүн байж болно |

## ДӨРӨВ. ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР БҮРИЙН ХУВААРИЛАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ АРГАЧЛАЛ

### 4.1 Нэвтрүүлгийн орлогын хуваарилалт

Радио, телевизийн нэвтрүүлгийн орлогыг cue sheet мэдээлэлд үндэслэн дуу, бичлэг бүрт хуваарилна.

- ▶ FKMP BROMIS систем: 36 нэвтрүүлэгч, 175 сувгаас ашиглалтын мэдээлэл автоматаар цуглуулна. ISRC кодоор дуу, бичлэг таних, цаг минутаар тооцоолно.
- ▶ IFPI CMO Toolkit (2024): "Usage-based distribution — royalties distributed based on actual usage data (cue sheets, playlists)"
- ▶ МУ-ын ХУБ-ын журам (2021) 2.2.2: "олон нийтэд нэгэн зэрэг дамжуулахдаа... хуулийн дагуу лицензийн гэрээгээр дуу, бичлэгийг олон нийтэд тоглуулах, хуулбарлах, хуваарилах"

Нэвтрүүлгийн орлогын хуваарилалтын алхам:

1. Нэвтрүүлэгч сарын cue sheet ирүүлнэ → ISRC кодоор дуу, бичлэгтэй тохируулна
2. Тарифын дагуу МСПП-ийн нийт орлогыг тооцоолно
3. Орлогоос 20% захиргааны суутгал + 5% нөөцийн санд үлдэнэ
4. Үлдсэн 75%-ийг дуу бичлэг тус бүрийн ашиглалтын хувиар хуваарилна
5. Дуу бичлэг бүрийн дотор: 50% голлох гүйцэтгэгч, 50% мастер эзэмшигч

### 4.2 Дижитал стримингийн орлогын хуваарилалт

Стриминг орлогыг платформын тайлан дахь ашиглалтын тоогоор хуваарилна. ISRC кодоор дуу, бичлэг таних зайлшгүй шаардлагатай

- ▶ RIAK: Бичлэгийн эрх эзэмшигчийн хамаарах эрхийн тариф ~48.25% (стримингийн нийт орлогоос). МСПП хоёр эрхийг нэгтгэн (гүйцэтгэгч + мастер) авна.
- ▶ SoundExchange: Digital Performance Royalty — 17 U.S.C. §114. Платформ → SoundExchange → гүйцэтгэгч (45%) + мастер (50%) + нэмэлт сан (5%).
- ▶ MDPI судалгаа (Солонгос, 2023): "The rights for a single music source can be divided into copyright and neighboring rights (production rights and performance rights)" — ISRC, UCI кодоор нарийвчлан тооцоолно.

| Хуваарилалтын алхам                | Тайлбар                                                               | Хариуцах тал                   |
|------------------------------------|-----------------------------------------------------------------------|--------------------------------|
| 1. Платформын тайлан авах          | Сар бүр CSV/JSON форматаар ашиглалтын тайлан авна                     | Платформ (гэрээгээр үүрэгжсэн) |
| 2. ISRC кодоор тохируулах          | ISRC кодыг МСПП-ийн мэдээллийн сантай тохируулан дуу, бичлэгийг таних | МСПП IT систем (автомат)       |
| 3. МСПП-ийн нийт орлого тооцоох    | Платформын нийт орлого × 65% (стриминг) / × 8% (реклам)               | Систем (автомат томьёо)        |
| 4. Суутгал хийх                    | 20% захиргааны суутгал + 5% нөөцийн сан                               | Систем (автомат)               |
| 5. Дуу, бичлэг тус бүрт хуваарилах | Ашиглалтын тооны харьцаагаар тус бүрт хуваарилах                      | Систем (ISRC-д үндэслэн)       |
| 6. Гүйцэтгэгч + мастер хуваах      | 50:50 харьцаа — тохиролцсон хувийн дагуу                              | Систем + гэрээний мэдээлэл     |

|                   |                                     |                    |
|-------------------|-------------------------------------|--------------------|
| 7. Шилжүүлэг хийх | Банкны batch payment — улирал тутам | МСПП санхүү + Банк |
|-------------------|-------------------------------------|--------------------|

### 4.3 Олон нийтийн газрын орлогын хуваарилалт

Олон нийтийн газрын тогтмол тарифын орлогыг жилийн гэрээний нөхцөлд тохируулан хуваарилна.

- ▶ WPPT (1996) Art. 15: Гүйцэтгэгч ба фонограмм бүтээгч нийтийн газарт ашиглалтаас "шударга нөхөн төлбөр" авах эрхтэй.
- ▶ FKMP/RIAK: Нийтийн газрын тариф нь м<sup>2</sup>-д суурилсан тогтмол тариф. КОМСА-ийн тарифын 50% хэмжээгээр тогтооно (Солонгосын ЗЭ хуулийн 11-р зүйл — нэмэлт өөрчлөлтийн дагуу).
- ▶ МУ-ын ХУБ-ын журам (2021) 2.2.3: "Эрх эзэмшигчийн дуу бичлэгийг ашиглах талаар ашиглагчтай лицензийн гэрээ байгуулах"

Олон нийтийн газрын орлогын хуваарилалтын онцлог: Ашиглалтын нарийн мэдээлэл байдаггүй тул тогтмол тарифын орлогын ашиглалтын хувийн тооцоолол биш, харин гишүүдийн репертуарын харьцаагаар хуваарилна.

| Аргачлал                                | Тайлбар                                                                                            | Эрхзүйн үндэслэл                          |
|-----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|
| Репертуарын харьцаагаар                 | Нийт гишүүдийн дуу, бичлэгийн тооноос тухайн гишүүний дуу, бичлэгийн харьцаа                       | IFPI CMO Toolkit: "pro-data distribution" |
| Ашиглалтын чиглэлийн мэдээлэлд үндэслэн | Ресторан, клуб, дэлгүүр г.м. ангиллаар орлогыг ялгаж, тухайн ангилалд тохирох дуу, бичлэгт хуваана | FKMP: ангиллын тариф                      |
| 50:50 харьцаа — гүйцэтгэгч: мастер      | Нийтийн газрын орлогоос гүйцэтгэгч 50%, мастер 50%                                                 | SoundExchange загвар; WPPT Art. 15        |

### 4.4 Амьд тоглолтын орлогын хуваарилалт

Амьд тоглолтын тасалбарын орлогоос авах хамаарах эрхийн 1%-ийн тарифыг тоглогдсон дуу бичлэгийн тоогоор хуваарилна. Амьд тоглолтонд тоглогдож буй дуу, хөгжимд **midi**, **sequencer** болон **sample device** хэрэглэсэн тохиолдолд дуу бичлэг, бичлэгийн эрхийн 1% төлбөр авах эрх үүснэ. Бусад тохиолдолд уг эрхийг Москап дангаар хэрэгжүүлнэ.

- ▶ FKMP: Амьд тоглолтоос гүйцэтгэгчийн хамаарах эрхийн орлого — тасалбарын нийт орлогын хувиар тогтоосон тариф.
- ▶ WPPT Art. 6: Гүйцэтгэгч нь дараах эрхтэй: "the right of fixation of their unfixed performances" — амьд тоглолтод онцгой эрх хамаарна.
- ▶ Ромын конвенц (1961) Art. 7: Гүйцэтгэгч амьд тоглолтыг зөвшөөрөлгүй бичлэг хийх, дамжуулахыг хориглох эрхтэй.

Амьд тоглолтын орлогын тооцооллын томъёо:

**МСПП орлого = (Нийт тасалбарын борлуулалтын орлого × 70% × 1%) - Суутгал ÷ Нийт тоглогдсон дуу, бичлэгийн тоо × МСПП гишүүдийн дуу, бичлэгийн тоо**

Хуваарилалтын харьцаа:

- 50% → Тоглолтын голлох гүйцэтгэгч (Featured Artist)
- 50% → Хамтлагийн гишүүд, Хэсэгчилсэн гүйцэтгэгчид (дуу, бичлэгийн гэрээний дагуу)
- Хэрэв гүйцэтгэгч нь мастер эзэмшигч бол: гүйцэтгэгч + мастер нэгтгэж 100%

#### 4.5 Гадаадын орлогын хуваарилалт

Гадаадын ХУБ-уудаас WIPO-Connect/SCAPR дамжуулан хүлээн авах олон улсын роялтийг ISRC кодоор тохируулан гишүүдэд хуваарилна.

- ▶ SoundExchange & SAMPRA (2024): "Retroactive to 2022 distribution period" — харилцан гэрээний дагуу гадаадын орлогыг хуваарилна.
- ▶ SCAPR (дэлхийн гүйцэтгэгчдийн байгууллагуудын холбоо): Гишүүн ХУБ-уудын хооронд роялтийг ISRC кодоор тохируулан хуваарилна.
- ▶ FKMP (2024): Гадаадын орлого 1.34 тэрбум вон — өмнөх жилээс 193% өслөл. SoundExchange-тэй гэрээгээр АНУ-ын дижитал радиогийн орлого хүлээн авсан.
- ▶ WIPO-Connect (2024): ISNI+ISRC стандартаар гишүүдийг таних. 50 гаруй ХУБ ашиглаж байна.

| Гадаадын орлогын эх үүсвэр          | Хүлээн авах арга                        | Хуваарилалтын загвар                        |
|-------------------------------------|-----------------------------------------|---------------------------------------------|
| SoundExchange (АНУ) — дижитал радио | Харилцан гэрээ → WIPO-Connect → МСПП    | ISRC кодоор → 50% гүйцэтгэгч, 50% мастер    |
| SCAPR гишүүн ХУБ-ууд (130+ орон)    | SCAPR-ийн стандарт мэдэгдлийн хэлбэрээр | ISRC тохируулга → 50:50 хуваарилалт         |
| FKMP (Солонгос)                     | Харилцан гэрээ → DDEX формат            | MN дуу, бичлэгийн Солонгос дахь ашиглалтаар |
| PPL (Их Британи), GVL (Герман)      | SCAPR дамжуулан                         | ISRC-д үндэслэсэн ашиглалтын тооцоо         |

## ТАВ. ХУВААРИЛАЛТЫН ТОМЬЁО БА ТООЦООЛЛЫН СТАНДАРТ

### 5.1 Нэг дуу, бичлэгт хуваарилагдах дүнгийн тооцооллын ерөнхий томьёо

**Нэг дуу, бичлэгт хуваарилах нийт дүн =**

Нийт орлого  $\times$  (100% – 20% – 5%)  $\times$  (Тухайн дуу бичлэгийн ашиглалтын хувь)  
**= Нийт орлого  $\times$  75%  $\times$  Тухайн дуу бичлэгийн ашиглалтын хувь**

**Голлох гүйцэтгэгчид олгох дүн = Нэг дуу бичлэгийн дүн  $\times$  50%**

**Мастер эзэмшигчид олгох дүн = Нэг дуу бичлэгийн дүн  $\times$  50%**

### 5.2 Ашиглалтын хувийн тооцооллын аргачлал

| Орлогын ангилал    | Ашиглалтын хувийн томьёо                                                                       | Жишиг                                    |
|--------------------|------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|
| Нэвтрүүлэг         | Тухайн дуу, бичлэгийн нэвтрүүлэгдсэн минут $\div$ Нийт нэвтрүүлэгдсэн минут $\times$ 100%      | FKMP BROMIS: цаг минутаар тооцоолно      |
| Стриминг           | Тухайн дуу, бичлэгийн стримингийн тоо $\div$ Нийт стримингийн тоо $\times$ 100%                | RIAK, FKMP: stream count-аар             |
| Олон нийтийн газар | Тухайн гишүүний дуу, бичлэгийн тоо $\div$ Нийт гишүүдийн дуу, бичлэгийн нийт тоо $\times$ 100% | IFPI CMO Toolkit: pro-rata по repertoire |
| Амьд тоглолт       | Тоглогдсон дуу, бичлэгийн тоо $\div$ Нийт тоглогдсон дуу, бичлэгийн тоо $\times$ 100%          | FKMP: cue sheet-аар                      |
| Гадаад орлого      | Гадаадын ХУБ-ийн тайланд заасан ашиглалтын хувь — ISRC-д суурилсан                             | SCAPR стандарт                           |

### 5.3 Ашиглалтын мэдээлэл байхгүй тохиолдлын хуваарилалт

Тодорхой ашиглалтын мэдээлэл байхгүй (жишээ нь олон нийтийн газрын ангилал) тохиолдолд IFPI CMO Toolkit-ийн стандартаар репертуарын харьцаагаар хуваарилна.

- IFPI CMO Toolkit: "When actual usage data is not available, repertoire-based pro-rata distribution is acceptable" — репертуарын тоогоор хуваарилах нь зөвшөөрөгдөх аргачлал.
- FKMP: Нийтийн газрын тарифыг ашиглалтын нарийн мэдээлэлгүйгээр цуглуулж, нийт repertoire-ийн хувиар хуваарилна.

## ЗУРГАА. ХУВААРИЛАЛТЫН ЦАГ ХУГАЦАА БА ТАЙЛАН

### 6.1 Хуваарилалтын давтамж

- МСРР дүрэм 7.1: "ХУБ нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг жил бүр гаргана."
- МСРР дүрэм 7.2: "Тайлангийн мэдээллийг гишүүдэд цахим хаяг, вэб сайтаар дамжуулан ил тод мэдээллэнэ."
- МСРР дүрэм (Гишүүний эрх): "Төлбөрийн хуваарилалтын тайлан авах", "өөрийн дуу бичлэгийн ашиглалтын мэдээлэл авах"
- МСРР дүрэм (Гишүүний эрх): "Гэрээлэгч гишүүн нь зөвхөн өөрийн эрхээр улирал тутамд дуу бичлэг ашигласны хуваарилалтын дэлгэрэнгүй мэдээллийг авч байна."
- FKMP (Солонгос): Улирал тутмын хуваарилалт — (ОӨГ-д мэдэгдэл). 2024 оны 3-р улиралд мэдэгдсэн.
- SoundExchange (АНУ): Улирал бүр, хувиарлалт дуусгаснаас 45 хоногийн дотор шилжүүлнэ.

| Хуваарилалтын үе        | Хугацаа                         | Үйлдэл                                                      | Стандарт                     |
|-------------------------|---------------------------------|-------------------------------------------------------------|------------------------------|
| Орлого цуглуулалт       | Гэрээнд заах                    | Нэвтрүүлэгч, платформын тайлан авах, гэрээний төлбөр хураах | FKMP/RIAK: cap бүрийн тайлан |
| Тооцоолол ба тохируулга | Улирал дууссанаас хойш 30 хоног | ISRC тохируулга, ашиглалтын хувь тооцоо, суутгал хийх,      | SoundExchange: 45 хоног      |
| Хуваарилалт             | Дараагийн улиралд               | УЗ-ийн 2 гишүүний зөвшөөрөл                                 | ОУ стандарт                  |
| Банкны шилжүүлэг        | Дараагийн улиралд               | Batch payment → гишүүдийн данс                              | ОУ стандарт                  |
| Тайлан                  | Жил дотроо                      | Гишүүн бүрт PDF/цахим мэйл, апп-аар тайлан                  | WPPT Art. 20: ил тод байдал  |

### 6.2 Гишүүдэд ирүүлэх тайлангийн бүрэлдэхүүн

МСРР-ийн дүрмийн 7.2-т заасны дагуу "тайлангийн мэдээллийг гишүүдэд цахим хаяг, вэб сайтаар дамжуулан ил тод мэдээллэнэ." WPPT (1996) Art. 20 болон IFPI CMO Toolkit-ийн шаардлагын дагуу гишүүн бүрт дараах мэдээлэл агуулсан тайлан улирал бүр ирүүлнэ:

- Тухайн дуу, бичлэгийн ISRC код ба дуу, бичлэгийн нэр
- Орлогын эх үүсвэр (нэвтрүүлэг / стриминг / олон нийтийн газар / гадаад)
- Ашиглалтын тоо буюу хэмжээ
- Нийт тарифын орлого
- 20% захиргааны суутгал ба 5% нөөцийн сангийн суутгал
- Гүйцэтгэгчийн хувь (50%) ба мастер эзэмшигчийн хувь (50%)
- Шилжүүлсэн нийт дүн, банкны дансны мэдээлэл, огноо

Гишүүн нь тайлангийн талаар маргаан гаргах эрхтэй бөгөөд маргааныг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Үндэслэлтэй маргааны тохиолдолд нөөцийн сангаас нэмэлт хуваарилалт хийж болно.

- МСРР дүрэм 7.3: "2 жилд нэг удаа аудитын хяналтыг дараа жилийн санхүүгийн эхний улиралд багтаан УЗ-д тайлагнана."
- МСРР дүрэм 7.4: "Хяналтын хорооны саналаар УЗ-н хурлын 80 хувийн шийдвэрээр хөндлөнгийн аудит жилд 1 удаа оруулж болно."
- МСРР дүрэм 4.9.5: Хяналтын зөвлөл нь "гүйцэтгэх удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавина"

## ДОЛОО. ОНЦГОЙ НӨХЦЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

## 7.1 Бүртгэлгүй дуу, бичлэгийн орлого

- ▶ МУ-ын ХУБ-ын журам (2021) 3.1.9-д заасан нөөцийн сангийн зарчим: тодорхойлогдоогүй орлого нөөцийн санд хуримтлагдана.
- ▶ SoundExchange загвар: Бүртгэлгүй уран бүтээлчийн орлогыг "unclaimed royalties" гэж хуримтлуулан 3 жил хүлээнэ.
- ▶ IFPI CMO Toolkit: "Unidentified royalties should be held in reserve and distributed after a reasonable period"

МСПР-д бүртгэлгүй дуу бичлэгийн орлогыг:

1. Нөөцийн санд төвлөрүүлнэ.
2. Эрх эзэмшигч нь мэдэгдсэн тохиолдолд 3 жил хүртэлх хугацааны орлогыг буцаан олгоно

## 7.2 Гадаадын дуу бичлэгийн орлого (харилцан гэрээгүй орнуудын)

SCAPR, WIPO-Connect-ийн хамрах хүрээнд ороогүй орнуудаас ирж байгаа орлогыг дотоодын хуваарилалттай нэгтгэн хуваарилна. Гадаадын дуу бичлэгийн Монгол дахь ашиглалтаас үүссэн орлогыг харилцан гэрээтэй орнуудын ХУБ-уудад шилжүүлнэ.

## 7.3 Маргаан шийдвэрлэх

- ▶ МСПР дүрэм 3.2.11: " Өөрсдийн гишүүдийн хооронд болон ХУБ-ын хооронд гишүүний аль нэг дуу бичлэгийн эрх ба гишүүний бичлэгийн бусад эрхтэй холбоотой гарсан санал зөрөлдөөнийг зохицуулж шийдэх "
- ▶ МСПР дүрэм: "Хүндэт тэргүүлэгч, тэргүүлэгч болон гишүүн, гүйцэтгэх удирдлага ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзвэл жилд нэг удаа удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлүүлнэ."
- ▶ WPPT (1996) Art. 23: Гүйцэтгэгч ба фонограмм бүтээгч нь эрхийнхээ хамгааллын зорилгоор үйлдлийг зогсоох болон нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй.

- Гишүүн маргаан гаргаснаас 30 хоногийн дотор МСПР шийдвэрлэнэ
- Шийдэгдэхгүй тохиолдолд ОӨГ-ын зуучлалын үйлчилгээнд хандаж болно
- Шүүхийн шийдвэрийн дагуу нэмэлт хуваарилалт хийх эрх байна

## НАЙМ. ОРЛОГО ХУВААРИЛАЛТЫН НЭГТГЭСЭН ЗАГВАР

Дараах хүснэгт нь IFPI · RIAK · FKMP · SoundExchange-ийн олон улсын стандарт болон МУ-ын ХУБ-ын журмыг нэгтгэн МСПР-ийн хуваарилалтын бүтэн загварыг харуулна:

| Үе шат                            | Тооцооллын томьёо              | МСПР дүрмийн заалт     | Олон улсын стандарт                  | Хувь           |
|-----------------------------------|--------------------------------|------------------------|--------------------------------------|----------------|
| Нийт цуглуулсан орлого            | Тариф × Ашиглалтын хэмжээ      | Дүрэм 5.1–5.2          | МСПР тарифын хүснэгт                 | 100%           |
| (-) Захиргааны суутгал            | Нийт орлого × 20%              | Дүрэм 5.3              | МУ-ын ХУБ-ын журам 4.3               | –20%           |
| (-) Нөөцийн сан                   | Нийт орлого × 5% (хүртэл)      | Дүрэм 6.2              | МУ-ын ХУБ-ын журам                   | –5%            |
| Хуваарилах нийт орлого            | Нийт × 75%                     | Дүрэм 5.3, 5.4         | WPPT Art. 15                         | 75%            |
| → Голлох гүйцэтгэгч               | Хуваарилах × 50%               | Дүрэм 3.2.4            | SoundExchange 45%+FKMP+WPPT          | 37,5%          |
| → Мастер / эрх эзэмшигч           | Хуваарилах × 50%               | Дүрэм 3.2.4            | SoundExchange 50%+RIAK+Ромын конвенц | 37,5%          |
| → Нэмэлт гүйцэтгэгч (Хэсэгчилсэн) | Гүйцэтгэгчийн хувиас гэрээгээр | Дүрэм (гишүүний үүрэг) | SoundExchange 5% сан загвар          | Тохиролцоогоор |

Тайлбар: Дээрх загварт 75%-ийг хоёр хүлээн авагчид тэнцүү (50:50) хуваарилдаг нь SoundExchange-ийн хуулиар тогтоосон (17 U.S.C. §114), FKMP болон RIAK-ийн загвар, WPPT Art. 15-ийн "шударга нөхөн төлбөр"-ийн зарчимтай нийцнэ. Гүйцэтгэгчийн 50%-ийг лейблийн гэрээнээс үл хамааран шууд гүйцэтгэгчид олгоно — энэ нь SoundExchange-ийн хамгийн чухал уран бүтээлчийн эрхийн хамгаалалтын механизм юм.